



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/02

Өлгий

Г Өмч хамгаалах байнгын зөвлөлийн Т
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3, 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын Өмч хамгаалах Байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга	Ш.Аманбол - Эрүүл мэндийг дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагаа, байгууллагын дотоод ажил хариуцсан ажилтан
Нарийн бичиг	С.Еншигүл - Эрүүл мэндийн газрын ерөнхий нягтлан бодогч
Гишүүд	М.Халайх - Мэдээллийн технологи, телемедицин, зайн анагаах ухаан хариуцсан ажилтан С.Бекет - Барилгын чанар, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа, эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан 3.Атина - Уламжлалт, сэргээн засал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан ажилтан

2. Байгууллагын үндсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон зайлшгүй шаардлагатай эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах, байхгүй байгаа хөрөнгийг олох дахин үнэлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Өмч хамгаалах зөвлөлд даалгасугай.

3. Эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон ажиллахыг Зөвлөлд үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/70 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН

